

Монос Хүнс ХК

Санхүүгийн тайлан болон
Хараат бус аудиторын тайлан
2025 оны 12 сарын 31

**МОНОС ХҮНС ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАН
2025 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН ТАЙЛАНТ ЖИЛ**

АГУУЛГА

ХУУДАС

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

1

АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

2

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

3

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

4

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

5

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

Хүрэлбаатар овогтой Ананд би Монос Хүнс ХК (цаашид "Компани" гэх)-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргын хувьд, Агваандорж овогтой Отгондарь би тус Компанийн Гүйцэтгэх захирлын хувьд, Цэгмэд овогтой Дэлгэрмаа би тус Компанийн Санхүү хариуцсан захирлын хувьд ард хавсаргасан 1-ээс 45 хуудас дахь Компанийн 2025 оны 12-р сарын 31-нээрх санхүүгийн тайлангуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс батлан гаргасан холбогдох Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэсэн бөгөөд 2025 оны 12-р сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг үнэн зөв, шударгаар илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.



Х.Ананд

ТУЗ-ын дарга



А.Отгондарь

Гүйцэтгэх захирал



Ц.Дэлгэрмаа

Санхүү хариуцсан захирал



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Монос Хүнс ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд,

Санхүүгийн тайлангийн аудитын тайлан**Дүгнэлт**

Монос Хүнс ХК (цаашид "Компани" гэх)-ийн 2025 оны 12-р сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болгосон тайлант жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бид, дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь Компанийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл ("НБЗОУСЗ")-өөс баталж гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт- Нягтлан бодох бүртгэлийн стандартууд (цаашид "СТОУС-Нягтлан бодох бүртгэлийн стандартууд" гэх)-ын дагуу үнэн, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид "АОУС" гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид "НБЭЗОУСЗ-ын дүрэм" гэх)-ийн дагуу Компаниас хараат бус ба НБЭЗОУСЗ-ын дүрмийн дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал нь бидний мэргэжлийн үнэлэмжээр тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн ач холбогдолтой, нөлөө бүхий асуудал юм. Бид санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд энэхүү асуудлыг бүхэлд нь анхаарч авч үзсэн бөгөөд дүгнэлт гаргахдаа уг асуудлын талаар тусад нь дүгнэлт гаргаагүй болно. Бид дараах асуудлыг Аудитын гол асуудал гэж тодорхойлсон.

Аудитын гол асуудал**Орлого хүлээн зөвшөөрөлт**

Аудитын Олон Улсын Стандартаар борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлттэй холбоотой залилангийн эрсдэл аливаа байгууллагад зайлшгүй байдаг гэж үздэг. Борлуулалтын орлого нь удирдлагын гүйцэтгэлийг үнэлэх гол үзүүлэлтүүдийн нэг тул борлуулалт бодитоор үүссэн эсэх болон борлуулалтын орлогыг зөв тайлант үед хүлээн зөвшөөрч бүртгэсэн эсэх эрсдэлийг аудитын гол асуудал болгон авч үзсэн.

Бидний гүйцэтгэсэн аудитын горимууд

Борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөхтэй холбоотой бидний гүйцэтгэсэн горимууд:

- Бид удирдлагын зүгээс борлуулалтын орлого нь бодитоор үүссэн болон зөв тайлант хугацаанд бүртгэгдсэн эсэхийг хянаж буй хяналтуудын талаар ойлголт олж авч тэдгээрийн загварчлалыг үнэлж, хэрэгжилтийг шалгасан.
- Компаний орлого хүлээн зөвшөөрөх нягтлан бодох бүртгэлийн бодлого нь СТОУС 15 - *Худалдан авагчтай байгуулсан гэрээний орлого* -той нийцэж буй эсэхийг үнэлсэн.

Onch & Company тухай

Onch & Company нь Монгол Улсын Оюуны өмчийн газарт бүртгэлтэй барааны тэмдэг юм. Энэхүү тэмдэгийг Онч Аудит ХХК, Онч Зөвлөх үйлчилгээ ХХК, Онч Татварын Зөвлөх үйлчилгээ ТМЗ ХХК-иуд ашиглах эрхтэй бөгөөд тэдгээр нь аудит, эрсдэлийн удирдлага, татвар болон хуулийн зөвлөгөө, консалтинг болон санхүүгийн зөвлөгөө зэрэг мэргэжлийн үйлчилгээг Монголын харилцагчдад үзүүлдэг байгууллагууд юм.

Тус баримт бичигт ерөнхий мэдээлэл агуулагдсан бөгөөд энэхүү танилцуулгаар Onch & Company, түүний гишүүн компани, холбоотой талуудыг мэргэжлийн зөвлөгөө өгсөнд эсвэл үйлчилгээ үзүүлсэнд тооцогүй. Та өөрийн санхүү, бизнест нөлөөлөхүйц ямарваа шийдвэр гаргах эсвэл үйлдэл хийхээс өмнө мэргэжлийн зөвлөхөд хандан зөвлөгөө авна уу. Энэхүү танилцуулгад найдаж шийдвэр гаргасан эсвэл үйлдэл хийсний улмаас ямарваа хохирол учирсан бол бид ямарваа хариуцлага хүлээхгүй болно.

© 2025. Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл Onch & Company-тай холбогдоно уу.

Аудитын гол асуудал (үргэлжлэл)

Аудитын гол асуудал

Бидний гүйцэтгэсэн аудитын горимууд

- Компаний томоохон харилцагчидтай жилийн туршид хийгдсэн борлуулалтын орлогыг тулган баталгаажуулсанаас гадна борлуулалтын тоо хэмжээ болон үнийн мэдээлэлд үндэслэн нийт борлуулалтын орлогын хүлээгдэж буй хэмжээг тооцоолж санхүүгийн тайланд бүртгэгдсэн борлуулалтын орлоготой харьцуулж шалгасан.
- Борлуулалтын орлогыг гүйцэтгэлийн үүрэг хангагдсан үед хүлээн зөвшөөрсөн эсэхийг шалгах үүднээс жилийн туршид хийгдсэн борлуулалтын ажил гүйлгээнээс түүвэр сонгон авч борлуулсан бараа материалын хүргэлтийг худалдан авагч тал хүлээн зөвшөөрсөн эсэхийг нотлох холбогдох баримт бичгүүдтэй тулгаж шалгасан.

Бусад мэдээлэл

Компанийн удирдлага нь бусад мэдээллийн талаар үүрэг хүлээнэ. Бусад мэдээлэлд жилийн тайлан багтах бөгөөд санхүүгийн тайлан болон энэхүү аудиторын дүгнэлт багтахгүй.

Энэхүү санхүүгийн тайланд өгсөн манай аудиторын дүгнэлт нь бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид бусад мэдээлэлд ямар нэгэн баталгаажуулах дүгнэлт өгдөггүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй бөгөөд бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитын ажлын хүрээнд олж мэдсэн мэдээллээс материаллагаар зөрүүтэй эсвэл зөрүүтэй мэт харагдаж байгаа эсэхийг авч үзэх ёстой. Хэрэв бид хийсэн ажил дээрээ үндэслэн бусад мэдээлэл нь материаллаг алдаатай байна гэж үзвэл бодит мэдээллийг тайлагнах үүрэгтэй. Үүнтэй холбоотойгоор ямар нэгэн тайлагнах зүйл байгаагүй болно.

Санхүүгийн Тайлантай холбоотой Удирдлага болон Засаглах Эрх Бүхий Этгээдийн Үүрэг

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС- Нягтлан бодох бүртгэлийн стандартуудын дагуу бэлтгэн шударгаар илэрхийлэх, эдгээр санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний алдаагүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Удирдлага санхүүгийн тайланг бэлтгэх үедээ Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, уг чадамжид нөлөөлөхүйц нөхцөл байдлын талаар шаардлагатай үед тодруулах болон Компанийг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг ашиглан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэгтэй.

Засаглах эрх бүхий этгээд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг

Санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа эсвэл санаатай зальт үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайланг гарган гэрээт ажлын гэрээнд заасан эрх бүхий этгээд болох та бүхэнд хүргүүлэх нь бидний зорилго юм. Энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бид аливаа бусад этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь байнга материаллаг хэмжээний алдааг илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй. Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөхөөр хүлээгдэж байвал бол материаллаг гэж үздэг.

Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг (үргэлжлэл)

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг болгож, бид аудитын туршид мэргэжлийн үнэлэмж болон үл итгэх үзлийг баримталсан болно. Мөн түүнчлэн:

- Залилан болон алдаанаас үүсэж болохуйц санхүүгийн тайлангийн материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлон үнэлж, уг эрсдэлүүдэд тохирох аудитын горимуудыг боловсруулан гүйцэтгэж, аудитын дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай болон зохистой аудитын баримт, нотолгоог олж авна. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг. Учир нь залилан нь үгсэн тохирох, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, худал батламж гаргах болон дотоод хяналтыг зөрчих зэрэг явдлуудаас үүссэн байх магадлалтай байдаг.
- Бид Компанийн дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус зөвхөн нөхцөл байдалд тохирох аудитын горимуудыг сонгох зорилгоор дотоод хяналтуудыг судалдаг.
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын зохистой байдал болон удирдлагын бэлтгэсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгуудын зохистой байдлыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн тасралтгүй байх нөхцөлийг үргэлжлүүлэн хангах Компанийн чадварт мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал болон материаллаг тодорхой бус байдал үүссэн эсэхийг үнэлдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал байгаа гэж үзвэл санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг аудиторын дүгнэлтэд тусгаж анхааруулах, мөн тэдгээр тодруулгууд нь зохистой биш гэж үзсэн тохиолдолд бид дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай байдаг. Бид дүгнэлтээ аудиторын тайлангийн өдөр хүртэлх олж авсан аудитын нотлох баримтад үндэслэн гаргадаг. Тиймээс ирээдүйд болох үйл явдал эсвэл нөхцөл байдал нь Компани үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэхэд саад учруулж болох юм.
- Санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг бүхэлд нь үнэлдэг ба ажил гүйлгээ, үйл явдлуудыг санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахуйц байдлаар толилуулсан эсэхийг үнэлдэг.

Аудитор нь засаглах эрх бүхий этгээдтэй зөвхөн аудитын ажлын цар хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад илэрсэн ач холбогдол бүхий асуудлуудын талаар мэдээлдэг ба үүнд аудитын үеэр аудиторын илрүүлсэн дотоод хяналтын томоохон алдаа болон дутагдал орно.

Мөн бид өөрсдийн хараат бус байдлыг хөндсөн ёс зүйн шаардлагуудыг хангасан тухай мэдэгдлийг засаглах эрх бүхий этгээдүүдэд хүргэж, бидний хараат бус байдалд зохистойгоор хамааралтай гэж үзэж болох бүхий л харилцаа, бусад асуудлуудын талаар болон хэрвээ шаардлагатай тохиолдолд аливаа эрсдэлийг арилгахаар авсан арга хэмжээг мэдэгддэг.

Засаглах эрх бүхий этгээдэд мэдэгдсэн асуудлаас бид тухайн тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн өндөр ач холбогдол бүхий асуудлуудыг аудитын гол асуудлууд гэж тодорхойлдог. Хууль тогтоомж нь уг асуудлуудын талаар олон нийтэд мэдээлэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайланд тухайн асуудлуудын талаар мэдээлэх нь олон нийтийн хүртэх үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлуудыг бид аудиторын тайландаа толилуулдаг.



Б. Уранбилэг
Партнер, МНБ

Ерөнхий мэдээлэл
2025 оны 12-р сарын 31-ээр тасалбар болгосон тайлант жил

Компанийн нэр **Монос Хүнс ХК**

Улсын бүртгэлийн дугаар 9010002005

Үндсэн үйл ажиллагаа Компанийн үндсэн үйл ажиллагаа нь шүүс, ус, ундаа, чихэр, үрэл, цай, зөөлөн капсултай бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон гадаад худалдаа болно.

Хувьцаа эзэмшигчид:	Хувьцааны тоо	Эзэмшлийн хувь
Л.Хүрэлбаатар	286,198,433	70.00%
Ц.Цэцэнзориг	14,284,706	3.49%
Ц.Ганзориг	14,120,665	3.45%
Х. Ананд	10,929,975	2.67%
А. Түмэнжаргал	5,996,176	1.47%
Л. Эрдэнэчимэг	4,630,628	1.14%
Б. Пунсалмаа	3,093,249	0.76%
Бусад	69,596,596	17.02%
	408,850,428	100%

Гүйцэтгэх Удирдлага

Гүйцэтгэх захирал	А.Отгондарь
Санхүү хариуцсан захирал	Ц.Дэлгэрмаа
Борлуулалт, маркетинг хариуцсан захирал	Э.Амарболд
Үйлдвэрлэл хариуцсан захирал	Б.Баянжаргал

Төлөөлөн удирдах зөвлөл

ТУЗ-ийн дарга	Х.Ананд
ТУЗ-ийн хараат бус гишүүн	Г.Золжаргал
ТУЗ-ийн хараат бус гишүүн	Н.Улаанхүү
ТУЗ-ийн хараат бус гишүүн	М.Сарандаваа
ТУЗ-ийн хараат бус гишүүн	Д.Гэрэлт-Од
ТУЗ-ийн хараат бус гишүүн	Д.Энхжаргал
ТУЗ-ийн хараат бус гишүүн	Б.Бат-Уул
ТУЗ-ийн хараат гишүүн	Л.Хүрэлбаатар
ТУЗ-ийн хараат гишүүн	А.Отгондарь
ТУЗ-ийн хараат гишүүн	Х.Солонго
ТУЗ-ийн хараат гишүүн	Ц.Цэцэгбадам
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	Н.Цагаанхүү

Байнгын хаяг

Монос Хүнс ХК
Үйлдвэр, Сонсголонгийн зам гудамж,
32/3 тоот, Үйлдвэрийн баруун бүс,
БГД, 20-р хороо, Улаанбаатар хот,
Монгол улс

Аудитор

Онч Аудит ХХК
15-р давхар, Ай Си Си цамхаг,
Жамьян гүний гудамж, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Улаанбаатар хот,
Монгол улс

МОНОС ХҮНС ХК
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2025 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	Тодруулга	2025	2024
Хөрөнгө			
<i>Эргэлтийн хөрөнгө</i>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5	53,185	2,292,388
Дансны ба бусад авлага	6	7,433,664	5,497,442
Урьдчилгаа	7	962,238	544,383
Бараа материал	8	8,040,808	7,806,736
Бусад эргэлтийн хөрөнгө	9	-	1,428,799
		16,489,895	17,569,748
<i>Эргэлтийн бус хөрөнгө</i>			
Үндсэн хөрөнгө	10	38,036,346	35,455,386
Ашиглах эрхтэй хөрөнгө	11	3,757,625	2,589,657
Биет бус хөрөнгө	12	298,099	327,070
Урьдчилгаа	7	2,293,251	2,951,402
Хойшлогдсон татварын хөрөнгө	17	62,855	95,157
		44,448,176	41,418,672
Нийт хөрөнгө		60,938,071	58,988,420
Өр төлбөр ба эздийн өмч			
<i>Богино хугацаат өр төлбөр</i>			
Дансны ба бусад өглөг	13	4,914,965	3,949,391
Гэрээний өр төлбөр	14	130,716	93,651
Богино хугацаат зээл	15	5,966,648	12,979,016
Хойшлогдсон засгийн газрын буцалтгүй тусламж	15	1,200,788	1,678,419
Түрээсийн өр төлбөр	11	1,624	116,255
Орлогын албан татварын өглөг	17	73,599	337,059
Нөөц	8	270,203	239,115
		12,558,543	19,392,906
<i>Урт хугацаат өр төлбөр</i>			
Урт хугацаат зээл	15	17,333,220	13,507,432
Хойшлогдсон засгийн газрын буцалтгүй тусламж	15	1,266,780	2,467,568
Түрээсийн өр төлбөр	11	102,495	66,972
		18,702,495	16,041,972
Нийт өр төлбөр		31,261,038	35,434,878
Эздийн өмч			
Хувьцаат капитал	16	2,318,182	2,318,182
Нэмж төлөгдсөн капитал	16	6,835,733	6,835,733
Хуримтлагдсан ашиг		20,523,118	14,399,627
		29,677,033	23,553,542
Нийт өр төлбөр ба эздийн өмч		60,938,071	58,988,420

Санхүүгийн тайлангуудын тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МОНОС ХҮНС ХК
АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН
2025 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	Тодруулга	2025	2024
Борлуулалтын орлого	18	47,803,112	37,993,254
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	19	(22,535,148)	(19,715,030)
Нийт ашиг		25,267,964	18,278,224
Бусад үйл ажиллагааны орлого		450,935	66,054
Ерөнхий ба удирдлагын зардал	20	(5,498,570)	(4,331,963)
Борлуулалт ба маркетингийн зардал	21	(11,509,325)	(8,303,161)
Бусад зардал	23	(340,657)	(206,206)
Үйл ажиллагааны ашиг		8,370,347	5,502,948
Санхүүгийн орлого	24	48,611	177,218
Санхүүгийн зардал	24	(2,312,277)	(1,107,243)
Дансны авлагын үнэ цэнийн бууралтын алдагдал		(104,429)	-
Бусад олз ба гарз	25	2,614,409	(10,409)
Татварын өмнөх ашиг		8,616,661	4,562,514
Орлогын албан татварын зардал	17	(857,769)	(511,814)
Тайлант жилийн цэвэр ашиг		7,758,892	4,050,700
Нэгж хувьцаанд ногдох ашиг (төгрөгөөр)	16.4	18.98	9.91

Санхүүгийн тайлангуудын тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**МОНОС ХҮНС ХК
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2025 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагд- сан ашиг	Нийт
2024 оны 1 сарын 1-ний дүн	2,318,182	6,835,733	10,348,927	19,502,842
Тайлант жилийн ашиг	-	-	4,050,700	4,050,700
2024 оны 12 сарын 31-ний дүн	2,318,182	6,835,733	14,399,627	23,553,542
Тайлант жилийн ашиг	-	-	7,758,892	7,758,892
Олгосон ногдол ашиг (Тодруулга 16.3)	-	-	(1,635,401)	(1,635,401)
2025 оны 12 сарын 31-ний дүн	2,318,182	6,835,733	20,523,118	29,677,033

Санхүүгийн тайлангуудын тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МОНОС ХҮНС ХК
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2025 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	Тодруулга	2025	2024
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Тайлант жилийн цэвэр ашиг		7,758,892	4,050,700
Тохируулга:			
Орлогын албан татварын зардал	17	857,769	511,814
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	10	2,289,540	1,281,952
Биет бус хөрөнгийн хорогдлын зардал	12	74,829	108,548
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдлийн зардал	11	386,449	131,017
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн бодит бус гарз/(олз)		23,578	(5,034)
Найдваргүй авлагын зардал		104,429	-
Бараа материал данснаас хассаны гарз	23	217,293	199,684
Бараа материалын (буцаалт)/хорогдол		(26,957)	26,957
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	10,25	52	633
Бусад эргэлтийн хөрөнгө борлуулсаны олз	25	(2,611,015)	-
Түрээсийн нөхцөл өөрчилсний олз	11	-	(16,259)
Ашиглах эрхтэй хөрөнгө данснаас хассаны олз	11	(3,446)	(922)
Хүүгийн орлого	24	(23,289)	(150,462)
Зээлийн хүүгийн зардал	16	2,077,189	988,874
Түрээсийн хүүгийн зардал	11	27,327	32,868
		11,152,640	7,160,370
Бараа материалын өсөлт		(424,408)	(3,088,455)
Дансны ба бусад авлагын өсөлт		(2,040,652)	(1,362,396)
Урьдчилгаа төлбөрийн (өсөлт)/бууралт		(757,204)	137,441
Дансны ба бусад өглөгийн өсөлт		480,261	34,366
Гэрээний өр төлбөрийн өсөлт		37,065	45,152
		8,447,702	2,926,478
Төлсөн орлогын албан татвар	17	(1,088,927)	(395,850)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		7,358,775	2,530,628
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн		(4,639,851)	(2,085,421)
Ашиглах эрхтэй хөрөнгө худалдан авахад төлсөн		(402,633)	(2,719,140)
Бусад эргэлтийн хөрөнгө борлуулсанаас орсон мөнгөн орлого		4,450,000	-
Биет бус хөрөнгө худалдан авахад төлсөн	12	(45,858)	(21,573)
Хүлээж авсан хүү	24	23,289	150,462
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(615,053)	(4,675,672)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Авсан зээл	15	24,476,000	18,377,364
Төлсөн зээл	15	(29,371,081)	(38,437,284)
Төлсөн зээлийн хүү	15	(2,195,171)	(2,906,826)
Төлсөн ногдол ашиг	16	(1,635,401)	-
Төлсөн түрээсийн өр төлбөр	11	(257,272)	(133,527)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(8,982,925)	(23,100,273)
Мөнгөний үлдэгдэл дэх ханшийн зөрүүгийн нөлөөлөл		-	226
Мөнгөн хөрөнгийн бууралт		(2,239,203)	(25,245,091)
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	5	2,292,388	27,537,479
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5	53,185	2,292,388

Санхүүгийн тайлангуудын тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.